


Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2021 оны 11 сарын 29-ны өдрийн А/69-тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



**СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН
ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН
МЭДЭЭНИЙ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР**



АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 3
2. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН МЭДЭЭНИЙ МАЯГТЫН ТУХАЙ ..
.....3-4
3. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН МЭДЭЭНИЙ
МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР5-10
4. УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН МЭДЭЭНИЙ
МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР 11-14

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан (БМС)-гийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээний маягт нь удирдах дээд болон эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, олон нийтийг соёлын өвийн тоон дүн статистикийн мэдээллээр хангах эх сурвалж баримт болно.

1.2. Монгол Улсын Статистикийн мэдээллийн маягт MN5522:2005 стандартыг баримтлан энэхүү түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээний маягтыг боловсруулав.

1.3. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.2 дахь заалтын дагуу тайлагнахдаа соёлын өвийн БМСанд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүнгийн мэдээг гаргаж, нэгтгэхэд энэхүү маягтыг ашиглана.

1.4. Соёлын өвийн БМСангууд нь энэхүү маягтыг үзүүлэлт бүрээр, бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөж, маягтад заасан графикт хугацааны дагуух урсгалаар шат, шатны БМСангуудад маягт болон албан ёсны цахим шуудангаар хүргүүлнэ.

1.5. Соёлын өвийн тоон дүн мэдээг хүргүүлэхдээ маягт болон эксел (Excel) программ дээр хийгдсэн тоон дүнг бичгэн хэлбэрт оруулан (Word дээр хийж) мөн маягт болон цахимаар цуг ирүүлнэ.

1.6. Мэдээний маягтыг ирүүлэхдээ хянасан байгууллагын захирал, мэдээ нэгтгэж гаргасан БМСанч нар тус, тус гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

1.7. Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын RICH-3 программын дата баазыг жил бүрийн 12 дүгээр сарын 01-ны дотор СӨУНБМСанд илгээх ажлыг зохион байгуулна.

ХОЁР. ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН МЭДЭЭНИЙ МАЯГТЫН ТУХАЙ

2.1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жилийн мэдээ нь дараах үндсэн 2 маягтаас бүрдэж байгаа болно. Үүнд:

2.1.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээ

2.1.2. Судалгаа шинжилгээнд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 20... оны мэдээ

2.2. Хураангуй болон дэлгэрэнгүй байдлаар гаргаж буй маягтын тоон дүн хоорондоо зөрүүгүй, бүрэн гүйцэд байна.

2.3. Аймаг, нийслэлийн БМС 1.1 (1.1.1-1.1.3 хүртэл) мэдээний маягтуудыг тус тус нөхөж маягтад заасан графикт хугацаанд шатлалын дагуух БМСанд хүргүүлэх ба улсын нэгдсэн БМСан аймаг, нийслэлийн БМСангуудаас ирүүлсэн мэдээг маягт 1.2.(1.2.1-1.2.2)-ын дагуу нөхөж соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.4. Шат, шатны БМСангуудын нөхөх “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 20... оны мэдээ”-ний маягтуудын үзүүлэлтүүд зарчмын хувьд нь ижил байгаа бөгөөд “аймаг, нийслэлийн” болон “улсын нэгдсэн” БМСангийн нөхөх маягтууд соёлын өвийн тоон дүнг нэгтгэх үзүүлэлтээр ялгаатай болно.

2.5. Мэдээний маягт дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын “Төрөл зүйл”-ийн үзүүлэлт нь “RICH”-ийн бүртгэл дэх “Төрөл зүйл”-ийн ангилал болно.

2.6. Тайлант хугацаа нь өмнөх оны 11 дүгээр сарын 25-ноос дараа оны 11 дүгээр сарын 25-ныг дуусталх хугацаа болно.

2.7. БД-баганын дугаар, МД-мөрийн дугаар болно.

2.8. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээний маягтын асуулга, агуулгыг өөрчлөхийг хориглоно.

--o0o---

**ГУРАВ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН
МЭДЭЭНИЙ МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР**

Аймаг, нийслэлийн БМСангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын оны мэдээний маягт нь “бүртгэл, хадгалалт хамгаалалтын” болон “судалгаа шинжилгээнд хамрагдсан” хэмээх агуулгын хүрээнд үндсэн 2 төрлийн маягтаас бүрдэж байгаа юм.

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээний маягт дотроо хураангуй ба дэлгэрэнгүй гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 - Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээ (1.1.1) маягт хураангуй тоон дүнгийн,
 - Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээ (1.1.2) маягт дэлгэрэнгүй тоон дүнгийн
- Судалгаа шинжилгээнд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 20.... оны мэдээ (1.1.3) маягтууд юм.

3.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээ (1.1.1) маягтыг нөхөх заавар /хураангуй тоон дүнгийн/

Баганаар		
БД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1-2	Нэгдсэн дүн	RICH.3 программд бүртгэгдсэн болон тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн, ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан, хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт дүнг дурсгалт газар болон дурсгалаар ангилан бичнэ.
3-18	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	RICH.3 программд бүртгэгдсэн болон тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн, ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан, хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон үл хөдлөх дурсгалуудыг хамаарах төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичнэ.
19-22	Хамгаалалтын зэрэглэл	RICH.3 программд бүртгэгдсэн болон тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн, ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан, хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон үл хөдлөх дурсгалуудаас эрх зүйн хамгаалалтад байх эсхүл хамгаалалтад ороогүй дурсгалын тоон дүнг бичнэ.
Мөрөөр		
МД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1	Шинээр бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Өмнөх оны 11 дүгээр сарын 25-ноос хойших хугацаанд аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
2	Музейн хайгуул, судалгаагаар бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Музейн судалгаагаар илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.

3	Эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
4	Иргэдийн мэдээллээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэдийн мэдээллээр илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалыг тоон дүнг бичнэ.
5	Бусад эх сурвалжаар бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Бусад эх сурвалжаар аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
6	20... оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар БМСанд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Өмнөх оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар БМСанд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүнг бичнэ.
7	Үүнээс RICH.3 програмд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	БМСанд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас RICH.3 програмд бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
8	RICH.3 програмд бүртгэгдээгүй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	БМСанд шинээр бүртгэгдсэн боловч RICH.3 програмд оруулж амжаагүй дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
9	Тайлант хугацаанд БМСанд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалуудаас RICH.3 програмд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	Өмнөх оны 11 дүгээр сарын 25-ноос хойших аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг RICH.3 програмд оруулсан тоон дүнг бичнэ.
10	20... оны байдлаар RICH.3 програмд бүртгэлтэй нийт үл хөдлөх дурсгалын тоон дүн	Тайлант хугацааны байдлаар RICH.3 програмд бүртгэлтэй нийт үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичнэ.
11	Ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	Харьяалах нутаг дэвсгэрийн засаг захиргаа өөрчлөгдсөн (харьяаллаас хасагдсан) түүх, соёлын дурсгалт газрын тоог бичнэ.
12	Гэрээгээр эзэмшүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй түүх, соёлын дурсгалт газрын тоог бичнэ.
13	Эзэмшигч, өмчлөгч өөрчлөгдсөн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Дурсгалт газар болон дурсгалын эзэмшигч буюу хамгаалагч өөрчлөгдсөн тохиолдолд тоон дүнг бичнэ. Энэ асуулга зөвхөн олон нийтийн газарт орших дурсгалт газар, дурсгалд хамаарахыг анхаарна уу.
14	Хадгалалт, хамгаалалтыг сайжруулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Хадгалалт хамгаалалтыг сайжруулсан буюу эх төрх байдлыг сэргээн засварласан, дурсгалд цэвэрлэгээ хийсэн, хашаа хайс барьсан, гэрээт харуулд хариуцуулсан, эрх бүхий байгууллагын шийдвэрээр нүүлгэн шилжүүлсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын нийт тоон дүнг бичнэ.

15	Эх төрх байдлыг сэргээн засварласан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Тухайн түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр анхны хэлбэр, төрхөд нь ойртуулах сэргээн засварлалт хийгдсэн тоог бичнэ.
16	Цэвэрлэгээ хийсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Дурсгалт газар болон дурсгал байрлах газарт орчны цэвэрлэгээ хийсэн тоон дүнг бичнэ.
17	Хашаа, хайс барьсан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Хамгаалах зорилгоор тойруулан хашаа хайс барьсан дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
18	Гэрээт харуулд хариуцуулсан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хяналт тавьж, хариуцах болсон дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
19	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нүүлгэн шилжүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллага харьяа удирдах байгууллагын шийдвэрээр анх байрласан газраас зөөж шилжүүлсэн дурсгалын тоон дүнг бичнэ.
20	Хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Нийгмийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр эрсдэлд орсон үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичнэ.
21	Гэмтсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын анхны хэлбэр, төрхөд өөрчлөлт орсон, дурсгалд хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр гэмтэл учирсан дурсгалын тоон дүнг бичнэ.
22	Тоногдсон үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан болон хууль бусаар ухсан дурсгалын тоон дүнг бичнэ.
23	Хууль бусаар зөөгдсөн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, хууль бусаар шилжүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичнэ.
24	Алга болсон үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүнийг бүрдүүлж байгаа хэсгүүд алга болсон дурсгалын тоон дүнг бичнэ.

3.2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээ (1.1.2) маягыг нөхөх заавар /дэлгэрэнгүй тоон дүнгийн/

Баганаар		
БД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1-2	Нэгдсэн дүн	RICH.3 программд бүртгэгдсэн болон тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн, ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан, хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт дүнг дурсгалт газар болон дурсгалаар ангилан бичнэ.
3-18	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	RICH.3 программд бүртгэгдсэн болон тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн, ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан, хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон үл хөдлөх

		дурсгалуудыг хамаарах төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичнэ.
19-26	Хамгаалалтын зэрэглэл	RICH.3 программд бүртгэгдсэн болон тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн, ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулсан, хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон үл хөдлөх дурсгалуудаас эрх зүйн хамгаалалтад байх эсхүл хамгаалалтад ороогүй дурсгалын тоон дүнг бичнэ.
27-28	RICH.3 программд оруулсан	Мөрийн асуулгын дагуух RICH.3 программд оруулсан дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
Мөрөөр		
МД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
	Шинээр бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Өмнөх оны 11 дүгээр сарын 25-ноос хойших хугацаанд аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
	Музейн хайгуул, судалгаагаар бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Музейн судалгаагаар илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Иргэдийн мэдээллээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэдийн мэдээллээр илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Бусад эх сурвалжаар бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Бусад эх сурвалжаар аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	Харьяалах нутаг дэвсгэрийн засаг захиргаа өөрчлөгдсөн (харьяаллаас хасагдсан) түүх, соёлын дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Гэрээгээр эзэмшүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй түүх, соёлын дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Эзэмшигч өөрчлөгдсөн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эзэмшигч, хамгаалагч өөрчлөгдсөн дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Хадгалалт, хамгаалалтыг сайжруулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Хадгалалт хамгаалалтыг сайжруулсан буюу эх төрх байдлыг сэргээн засварласан, дурсгалд цэвэрлэгээ хийсэн, хашаа хайс барьсан, гэрээт харуулд хариуцуулсан, эрх бүхий байгууллагын шийдвэрээр нүүлгэн шилжүүлсэн үл хөдлөх дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
	Эх төрх байдлыг сэргээн засварласан үл	Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр анхны хэлбэр, төрхөд нь ойртуулах сэргээн засварлалт хийгдсэн үл хөдлөх дурсгалын

хөдлөх дурсгалын тоон дүн	тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Цэвэрлэгээ хийсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Дурсгалт газар болон дурсгал байрлах газарт орчны цэвэрлэгээ хийсэн тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Хашаа, хайс барьсан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Хамгаалах зорилгоор тойруулан хашаа хайс барьсан дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Гэрээт харуулд хариуцуулсан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хяналт тавьж, хариуцах болсон дурсгалт газар, дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нүүлгэн шилжүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллага харьяа удирдах байгууллагын шийдвэрээр анх байрласан газраас нүүлгэн шилжүүлсэн дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Нийгмийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр эрсдэлд орсон үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Гэмтсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Дурсгалын анхны хэлбэр, төрхөд өөрчлөлт орсон, дурсгалд хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр гэмтэл учирсан үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Тоногдсон үл хөдлөх дурсгалын тоон дүн	Бүрэн бүтэн байдлын алдагдуулсан, хууль бусаар ухсан дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Хууль бусаар зөөгдсөн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, хууль бусаар зөөсөн үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.
Алга болсон үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүнийг бүрдүүлж байгаа хэсгүүд нь алга болсон дурсгалын тоон дүнг бичих ба түүний доод хэсэгт сум, дүүрэг, оршин байгаа газрын нэрсийг бичнэ.

3.3 Судалгаа шинжилгээнд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 20.... оны мэдээний маягт (1.1.3)-ыг нөхөх заавар

Баганаар		
БД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1	Д/д	Хүснэгтийг дэс дугаарлана.
2	Сум, дүүргийн нэр	Сум, дүүргийн нэрсийг цагаан толгойн нэрсийн дарааллаар бичнэ. Дурсгал оршин буй сум, дүүргийн засаг захиргааны нэгжийн албан ёсны нэрийг бүрэн гүйцэд, үнэн зөв бичнэ.
3	Дурсгалт газрын нэр	Дурсгал оршин буй газар усны нэрийг бүрэн гүйцэд, үнэн зөв бичнэ.
4	Судалгаа шинжилгээ хийсэн байгууллагын нэр	Тайлант хугацаанд судалгаа шинжилгээ хийсэн албан байгууллагын албан ёсны нэрийг бүрэн гүйцэд, үнэн зөв бичнэ.
5	Судалгаа шинжилгээ хийсэн хугацаа	Судалгаа шинжилгээ хийгдэж эхэлснээс дууссан хүртэлх хугацааг бүрэн гүйцэд, үнэн зөв бичнэ.
5-7	Судалгаа хийсэн хэлбэр /+/	Дурсгалт газар болон дурсгал дээр ямар хэлбэрийн судалгааг хийгдсэнийг / + / тэмдгээр тэмдэглэнэ.

8-9	Судалгаанд хамрагдсан дурсгалын нэгдсэн тоон дүн	Тайлант хугацаанд судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгалт газар болон дурсгалын нэгдсэн тоон дүнг бичнэ.
8-25	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.
26-29	Хамгаалалтын зэрэглэл	Судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгал Эрхзүйн хамгаалалтад орсон эсхүл ороогүй бол / + / тэмдгээр тэмдэглэнэ.
30-31	Аймаг, нийслэлийн БМС-д тайлан ирүүлсэн эсэх тийм/+, үгүй /-/	Аймаг, нийслэлийн БМСанд судалгаа шинжилгээ хийсэн байгууллага тайлан ирүүлсэн эсэхийг +, - тэмдгээр тэмдэглэнэ.
Мөрөөр		
д/д	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
		Хүснэгтийг дэс дугаарлана. Сум, дүүрэг, байгууллагыг цагаан толгойн нэрсийн дарааллаар бичнэ.
	Нийт	Баганын асуулгын дагуух нийт тоон дүн байна. + эсхүл – тэмдгээр тэмдэглэсэн баганын үзүүлэлтийн нийт тоо нь нийт авсан + тэмдэг эсхүл нийт авсан – тэмдгийн нийлбэр дүнг бичихийг анхаарна уу.

---oOo---

ДӨРӨВ. УЛСЫН НЭГДСЭН БМСАНГИЙН МЭДЭЭНИЙ МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

4.1 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалтын 20 ... оны мэдээ
(1.2.1) маягтыг нөхөх заавар /дэлгэрэнгүй тоон дүнгийн/

Баганаар		
БД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1-2	Бүгд (багана1)	Баганын үзүүлэлтийн нийт тоон дүнг нэгтгэн дурсгалт газар, дурсгалаар ангилан бичнэ.
3-46	21 аймаг, нийслэл	21, аймаг, нийслэлийн дурсгалт газар, дурсгалын тоо бичнэ.
Мөрөөр		
МД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1	Нийт тоон дүн	Баганын үзүүлэлтийн нийт тоон дүнг нэгтгэн бичнэ.
2	Шинээр бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Өмнөх оны 11 дүгээр сарын 25-ноос хойших хугацаанд аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
3-18	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.
19-22	Хамгаалалтын зэрэглэл	Тайлант хугацаанд бүртгэгдсэн дурсгалуудаас эрхзүйн хамгаалалтад орсон болон хамгаалалтад ороогүй дурсгалын тоон дүнг бичнэ.
23	Музейн хайгуул, судалгаагаар бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Музейн судалгаагаар илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
24	Эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
25	Иргэдийн мэдээллээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэдийн мэдээллээр илрүүлж аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалыг тоон дүнг бичнэ.
26	Бусад эх сурвалжаар бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Бусад эх сурвалжаар аймаг, нийслэлийн БМСанд шинээр бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
27	20... оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар БМСанд бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Өмнөх оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байгаа нийт дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
28-43	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.

44-47	Хамгаалалтын зэрэглэл	20... оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байгаа эрхзүйн хамгаалалтад орсон болон хамгаалалтад ороогүй дурсгалын тоон дүнг бичнэ.
48	Үүнээс RICH.3 программд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	20... оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байгаа нийт түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас RICH.3 программд бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
49	RICH.3 программд бүртгэгдээгүй түүх, соёлын үл хөдлөх тоон дүн	20... оны 11 сарын 25-ны өдрийн байдлаар Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн боловч үл хөдлөх дурсгалын RICH.3 программд оруулж амжаагүй дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
50	Тайлант хугацаанд БМСанд шинээр бүртгэсэн үл хөдлөх дурсгалуудаас RICH.3 программд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	Тайлант хугацаанд Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэгдэж RICH.3 программд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
51	20... оны байдлаар RICH.3 программд бүртгэлтэй нийт үл хөдлөх дурсгалын тоон дүн	20... оны эцсийн байдлаар үл хөдлөх дурсгалын RICH.3 программд бүртгэлтэй байгаа нийт дурсгалт газар болон дурсгалын тоог бичнэ.
52	Ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн	Харьяалах нутаг дэвсгэрийн засаг захиргаа өөрчлөгдсөн (харьяаллаас хасагдсан) түүх, соёлын дурсгалт газрын тоог бичнэ.
53-68	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд бүртгэгдсэн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.
69-72	Хамгаалалтын зэрэглэл	Тайлант хугацаанд Ашиглалт, эзэмшил өөрчлөгдсөн дурсгалуудаас эрхзүйн хамгаалалтад орсон эсхүл хамгаалалтад ороогүй дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
73	Гэрээгээр эзэмшүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй түүх, соёлын дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
74	Эзэмшигч өөрчлөгдсөн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Эзэмшигч, хамгаалагч өөрчлөгдсөн дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
75	Хадгалалт, хамгаалалтыг сайжруулсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Хадгалалт хамгаалалтыг сайжруулсан буюу эх төрх байдлыг сэргээн засварласан, дурсгалд цэвэрлэгээ хийсэн, хашаа хайс барьсан, гэрээт харуулд хариуцуулсан, эрх бүхий байгууллагын шийдвэрээр нүүлгэн шилжүүлсэн үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын нийт тоон дүнг бичнэ.
76-91	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд хадгалалт хамгаалалтыг сайжруулсан буюу эх төрх байдлыг сэргээн засварласан дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.
92-95	Хамгаалалтын зэрэглэл	Тайлант хугацаанд хадгалалт хамгаалалтыг сайжруулсан буюу эх төрх байдлыг сэргээн засварласан дурсгалуудаас

		эрхзүйн хамгаалалтад орсон эсхүл хамгаалалтад ороогүй дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
96	Эх төрх байдлыг сэргээн засварласан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр анхны хэлбэр, төрхөд нь ойртуулах сэргээн засварлалт хийгдсэн үл хөдлөх дурсгалын тоог бичнэ.
97	Цэвэрлэгээ хийсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Дурсгалт газар болон дурсгал байрлах газарт орчны цэвэрлэгээ хийсэн тоон дүнг бичнэ.
98	Хашаа, хайс барьсан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Хамгаалах зорилгоор тойруулан хашаа хайс барьсан дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
99	Гэрээт харуулд хариуцуулсан үл хөдлөх дурсгалын тоон дүн	Иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хяналт тавьж, хариуцах болсон дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
100	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр зөөж шилжүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллага харьяа удирдах байгууллагын шийдвэрээр анх байрласан газраас зөөж шилжүүлсэн дурсгалын тоон дүнг бичнэ.
101	Хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нийт тоон дүн	Нийгмийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр эрсдэлд орсон үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичнэ.
102-117	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.
118-121	Хамгаалалтын зэрэглэл	Тайлант хугацаанд Хадгалалт, хамгаалалтын эрсдэлд орсон дурсгалуудаас эрхзүйн хамгаалалтад орсон эсхүл хамгаалалтад ороогүй дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг бичнэ.
122	Гэмтсэн үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын анхны хэлбэр, төрхөд өөрчлөлт орсон, дурсгалд хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр гэмтэл учирсан үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичнэ.
123	Тоногдсон үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан, хууль бусаар ухсан дурсгалын тоон дүнг бичнэ.
124	Хууль бусаар зөөгдсөн дурсгалын тоон дүн	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, хууль бусаар шилжүүлсэн үл хөдлөх дурсгалын тоон дүнг бичнэ.
125	Алга болсон үл хөдлөх дурсгалын тоон дүн	Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүнийг бүрдүүлж байгаа хэсгүүд алга болсон дурсгалын тоон дүнг бичнэ.

4.2 Судалгаа, шинжилгээнд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 20.... оны мэдээний маягт (1.2.2)-ыг нөхөх заавар

Баганаар		
БД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1-3	Нэгдсэн тоон дүн	Үзүүлэлтийн нийт тоон дүнг дурсгалт газар, дурсгал /+/, -/ тэмдгийн тоо зэргээр ангилан бичнэ.
4	Судалгаа шинжилгээ хийсэн байгууллагын тоо	Тайлант хугацаанд судалгаа шинжилгээ хийсэн байгууллагын тоо аймаг, нийслэл тус бүрээр бичнэ.
5-7	Судалгаа хийсэн хэлбэр / + / тэмдгээр тэмдэглэсэн тоон дүнг	Дурсгалт газар болон дурсгал дээр ямар хэлбэрийн судалгааг хийгдсэнийг / + / тэмдгээр тэмдэглэсэн тоон дүнг бичнэ.
8-9	Судалгаанд хамрагдсан дурсгалын нийт тоон дүн	Тайлант хугацаанд судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгалт газар болон дурсгалын нэгдсэн тоон дүнг бичнэ.
10-25	Үл хөдлөх дурсгалын төрөл зүйлийн үзүүлэлт	Тайлант хугацаанд судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгалт газар болон дурсгалын тоон дүнг төрөл зүйлийн үзүүлэлт тус бүрээр бичнэ.
26-29	Хамгаалалтын зэрэглэл	Судалгаа шинжилгээнд хамрагдсан дурсгал Эрхзүйн хамгаалалтад орсон эсхүл ороогүй бол / + / тэмдгээр тэмдэглэснийг тоолж нийт тоон дүнг бичнэ.
30-31	Аймаг, нийслэлийн БМС-д тайлан ирүүлсэн эсэх	Аймаг, нийслэлийн БМСанд судалгаа шинжилгээ хийсэн байгууллага тайлан ирүүлсэн байдлыг “тийм +”, “үгүй -” тэмдгээр тэмдэглэнэ.
Мөрөөр		
МД	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн тодорхойлолт
1	Бүгд	Баганын үзүүлэлтийн нэгдсэн тоон дүнг бичнэ.
2-23	Аймаг, нийслэлийн нэр	Баганын асуулгын дагуух 21 аймаг, нийслэлийн тоон дүнг тус бүр бичнэ.

---oOo---